



**“ХАЙ БИ ОЙЛ” ХК – ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2018 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 9

Улаанбаатар

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг
зарлан хуралдуулах тухай**

Компанийн тухай хуулийн 61 дугаар зүйлийн 61.1.2 дахь заалтын дагуу хувьцаа эзэмшигчээс ирүүлсэн санал болон 62 дугаар зүйлийн 62.1.7, 65 дугаар зүйлийн 65.1, 65.4, 67 дугаар зүйлийн 67.1, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалт болон Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 07 сарын 27-ны өдрийн 244 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-ыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2018 оны 12 сарын 10-ны өдрийн Даваа гарагт 10:00 цагаас Баянгол зочид буудлын хурлын танхимд зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй.
 - 2.1. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр сонгох тухай
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах Бүртгэлийн өдрийг 2018 оны 11 сарын 19-ны өдөр байхаар тогтоосугай
4. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хүргэх хурлын зарыг Хавсралт № 01-оор баталж, 2018 оны 11 дугаар сарын 01 нд өдөр тутмын 2-оос доошгүй сонин, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон Биржийн цахим хуудсаар дамжуулан мэдээлж, зарыг давтан 2018 оны 11 сарын 16-ны өдөр анх мэдээлсэний дагуу нийтэд дахин мэдээлэхийг зохион байгуулах комисст даалгасугай.
5. Танилцах баримт бичгийн жагсаалт, Ээлжит бус хурлын дэгийг Хавсралт № 02-ээр баталж 2018 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн дотор багтаан хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер дилерийн компаниудад хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлж, тухайн өдрөөс эхлэн 09⁰⁰-17⁰⁰ цагийн хооронд СХД дүүрэг, 20 хороо, Сонголонгийн /18135/ -110 Үйлдвэрийн байранд ирж танилцах боломжыг бүрдүүлсүгэй.
6. Хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ын агуулгыг 03 дугаар хавсралтаар баталсугай.
7. Хувьцаа эзэмшигчээс “Санал авах хуудас”-ыг хүлээн авах сүүлийн өдрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах өдрийг хүртэл байхаар тогтсугай.

8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралаар хэлэлцэх асуудалтай холбогдсон жагсаалт болон тэдгээрийн бэлэн болгох эцсийн хугацааг Хавсралт № 04-оор баталсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралын мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хорооны "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам"-ын 1 дүгээр хавсралтаар батлагдсан загварын дагуу гаргаж холбогдох баримтын хамт 2018 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржид тус тус хүргүүлсүгэй.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын даргаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Б. Мянганбаяр, хурал зохион байгуулах комиссын даргаар Б.Мянганбаяр, гишүүнээр Д.Хандаа, Д.Тогосбаатар, Тооллогын комиссын даргаар Д. Тогосбаатар гишүүдээр О.Ганчимэг, Д. Хандаа нарыг тус тус томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.МЯНГАНБАЯР

